



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/36

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.3.22 дугаартай “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин /Өвөрхангай/-д зарцуулах төсөл арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин /Өвөрхангай/-д зарцуулах 500,000,000 (таван зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0077

Аймгийн Засаг даргын 2022 оны  
01 дүгээр сарын 08-ны өдрийн  
А/10 дугаар захирамжийн  
хавсралт

Эрүүл мэндийн сайдын төсвийн багцад батлагдсан XIX.3.22  
хуулийн дугаартай Өвөрхангай аймгийн Засаг даргад эрх шилжсэн  
эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж,  
түргэн тусламжийн автомашин /Өвөрхангай/ зардлын  
хуваарилалт

| № | Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр   | Төсөвт өртөг<br>/мянган<br>төгрөг/ |
|---|--|------------------------------------|
| 1 | Бүрд, Өлзийт, Тарагт, Сант, Уянга, Бат-Өлзий сумдын Эрүүл мэндийн төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн автомашин | 245000,0                           |
| 2 | Хархорин сумын Нэгдсэн эмнэлэгт бактериологийн лабораторийн тоног төхөөрөмж  | 125000,0                           |
| 3 | Арвайхээр сумын Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нүдний хагалгааны микроскоп   | 75000,0                            |
| 4 | Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд уламжлалтын тоног төхөөрөмж  | 55000,0                            |
|   | НИЙТ ДҮН   | 500000,0                           |

-оОо-